

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

七夕 / Танабата

— Цаасан туузанд хүслээ бичье —



七夕/Танабата (7-р сарын 7-ны өдөр) нь Орихимэ гүнж, Хикобоши хүү хоёр сүүн замыг гатлаад жилд нэг удаа уулзах боломжтой өдөр юм. Бүгдээрээ цаасан туузанд хүслээ бичээд, саса хулс модонд өлгөцгөөе.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна. (<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)



Сонирхолтой хэллэг зөндөө!

オノマトペ сурцгаая

クイズ

雨のオノマトペ

Q1

あめ 雨が ○○○○ ふ 降っている




Q2

あめ 雨が ○○○○ ふ 降っている



Q3

あめ 雨が ○○○○ ふ 降っている



えら ABC からそれぞれ選んでね!

A しとしと **B** ざあざあ **C** ぽつぽつ



オノマトペ гэдэг нь “にこにこ笑う/никонико инээх”, “床がつるつるすべる/шал цүрүцүрү гулсах” гэх мэт өдөр тутмын ярианд их хэрэглэгддэг 擬態語/ги-тайго (юм зүйлсийн төлөв байдлыг илэрхийлсэн үг) болон 擬音語/ги-онго (дуу авиаг илэрхийлсэн үг), 擬声語/ги-сэйго (хүн, амьтны дуу хоолойг илэрхийлсэн үг)-г нэгтгэсэн зүйл юм. Ялангуяа Япон хэлэнд Оノマトペ-гийн төрөл их байдаг гэгддэг ба Япон хэлийг суралцаж буй та бүхний хувьд, яриан дунд ономатопэ гарч ирсэн үед утгыг нь ойлгоход хэцүү тохиолдол гарч магадгүй юм.

Тааварт өгөгдсөн “雨/бороо”-г илэрхийлэх Оノマトペ-д “ざあざあ/заазаа”, “しとしと/шитошито”, “ぽつぽつ/поцүпоцү”-гаас

гадна “ぱらぱら/парапара”, “しょしょ/шёбошёбо”, “ざんざん/занзан” гэх мэт янз бүрийн төрөл байдаг. Мөн, өвдөлтийг илэрхийлэх хэллэгт “きりきり/кирикири”, “ずきずき/зүкизүки”, “ぴりぴり/пирипири”, “じんじん/жинжин”, “ずきんずきん/зүкинзүкин”, “ちくちく/чикүчикү”, “がんがん/ганган” гэх мэт Оノマトペ байдаг. Эмнэлэгт үзүүлэхдээ өөрийнхөө өвдөлтийн байдлыг Оノマトペ ашиглан илэрхийлж чадвал нөгөө талд илүү сайн ойлгогдох байх.

オノマトペ-гийн талаарх ойлголт гүнзгийрвэл, үг хэллэг баяжиж, яриа илүү саадгүй болно. Хөгжилтэйгөөр Оノマトペ сурцгаая.

Өөр зөндөө байна! Оノマトペ

Япон хэл судлалын үндэсний институтын сайтад Япон цагаан толгойн дарааллаар, категори бүрээр Оノマトペ-г танилцуулсан байгаа тул орж үзээрэй.

<https://www2.ninjal.ac.jp/Onomatope/index.html>



Сурах бичгээс сурцгаая.

JITCO нь төрөл бүрийн “Япон хэл суралцахад зориулсан сургалтын материал” худалдаалж байна. Ур чадварын дадлагын талбарт түгээмэл хэрэглэгддэг харилцан яриаг түлхүү суралцах боломжтой текст ч байгаа. Номноос гадна, CD, DVD, мөн е-сургалтын сургалтын материал ч байгаа. Сайтаар орж үзээрэй.

Сургалтын материалын онлайн дэлгүүр
<https://onlineshop.jitco.or.jp/>

Е-сургалт
<https://www.jitco.or.jp/ja/service/learning.html>



! Халуунд цохиулахаас болгоомжилцгооё!

Халуунд цохиулах гэж юу вэ?

“Халуунд цохиулах” гэдэг нь, агаарын температур болон чийгшил өндөр үед, биед агуулагдах ус болон давсны тэнцвэр алдагдсанаас болж үүсдэг өвчин юм. Гэнэт халуун болсон өдөр, удаан хугацааны дараа халуун орчинд биеэ хөдөлгөсөн тохиолдолд, биеийн температураа сайн тохируулж чадалгүйгээр, халуунд цохиулж унах хүн олширдог тул, онцгой анхаарах хэрэгтэй.

Халуунд цохиулахаас сэргийлэхийн тулд
■ Өөрөөн дотор бол агааржуулагч, сэнс ашиглан сэрүүцээрэй.
Хөшиг г.м-ийг ашиглан халуунаас сэргийлэх нь мөн үр дүнтэй байдаг.



Халуунд цохиулсны гол шинж тэмдгүүд

Хөнгөн шинж тэмдэг	☒ Нүд эрээлжлэх ☒ Булчингаар өвдөх	☒ Босч зогсоход толгой эргэх ☒ Зогсолтгүй хөлрөлт
Дунд зэргийн шинж тэмдэг	☒ Толгой өвдөх ☒ Бие сульдах (сульдаж ядрах) ☒ Хүч тамир байхгүй (хүч тэнхээ барагдаж эцэх)	☒ Бөөлжис цутгах
Хүнд шинж тэмдэг	☒ Ухаан санаа байхгүй ☒ Өндөр температуртай халууралт ☒ Эгц алхаж чадахгүй ☒ Дуудахад өгөх хариу нь хэвийн бус	☒ Таталт

* 環境省 熱中症～ご存じですか？予防・対策法～リーフレットより抜粋し、JIT00 が作成

■ Гадаа бол аль болох нимгэн хувцаслаж, нарны шүхэр, малгай хэрэглэн нарны хурц гэрлээс зайлсхийгээрэй.

■ Шингэн болон давсаа нөхөөрэй. Амаа цангахаас нь өмнө ойрхон ойрхон шингэнээ нөхөхийг хичээгээрэй.

Халуунд цохиулсан тохиолдолд яах вэ?

Халуунд цохиулсны шинж тэмдэг илэрвэл, сэрүүхэн газар руу шилжин, хувцсаа суллаж, биеэ хөргөөрэй. Шингэн, давс, амаар шингэн сэлбэх уусмал (усанд давс болон глюкоз найруулсан ундаа, эмийн сан г.м газраас худалдаж авах боломжтой)-ыг нөхнө. Өөрөө шингэн ууж чадахгүй, ухаан санаа байхгүй г.м тохиолдолд, түргэн тусламжийн машин дуудах зэргээр даруй эмнэлэгт үзүүлээрэй.

Халуунд цохиулахаас сэрэмжлүүлэх сэрэмжлүүлэг

Халуунд цохиулах аюул маш өндөр гэж таамаглагдах өдрийн өмнөх өдрийн орой, эсвэл тухайн өдрийн өглөө эрт муж тус бүрээр мэдээлдэг. Мэдээлэл нь телевиз, гамшгаас сэргийлэх зориулалтын радио холбоо, SNS-ээр дамжуулан цацагддаг. Халуунд цохиулахаас сэрэмжлүүлэх сэрэмжлүүлэг мэдээлэгдсэн үед аль болох гадагшаа гарахгүй гэх зэргээр сэргийлээрэй.

Халуунд цохиулах аюулын түвшнийг илэрхийлэх

“халууны индекс”-ийг харах боломжтой.


<https://www.wbgt.env.go.jp/>

かんきょうしょう ねつちゆうしょう よ ぼうじようほう
環境省 熱中症予防情報サイト




Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)



□に、一字の言葉を書きましょう。



Японд ирсний дараах сургалтанд оролцож буй Инзонези, Вьетнамаас ирсэн Ур чадварын дадлагажигч нар Японы соёлтой биечлэн танилцлаа. Калиграфын соёлтой танилцахдаа ханзаар нэрээ бичихэд өөрсдийгөө сорьжээ. Анх удаа хэрэглэж үзсэн бийр, ханши цаастай ноцолдонгоо, олон дахин бичиж үзээд, бүгдээрээ мундаг бичиж чаджээ.

※2024年2月投稿 監理団体：東京中小企業海外業務開発促進協同組合

Оролцохыг урьж байна.

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.
(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

Асуудал тулгарсан үед ...? (<https://www.otit.go.jp/notebook/>)

ОТИТ (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばのにほんご/Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



助詞はほかの言葉の下について、「他の言葉との関係が分かる」働きをします。
「空は」「空が」「空が」か迷いませんでしたか。
「は」「は」「空」というものは「空」というように他と区別して取り出すときに使います。
「が」「が」「空が」どんなに（広いなど）ということを表します。森から出て、下を向いて右の道を歩いた後、頂上で頭のうっばいの空の広さを実感するでしょう。
「は」と「が」——やさしいようで難しい言葉です。



Залгавар нь үгний ард орж, “тухайн үгний бусад үгтэй хамаарах хамаарлыг харуулах” үүргийг гүйцэтгэнэ. “空/сора/тэнгэр/は/ва” юу “空が/сора га” юу гэж эргэлзээгүй юу? “は/ва” нь “тэнгэр гэдэг нь” гэх мэтчилэн бусдаас ялгаж салгахад хэрэглэгдэнэ. “が/га” нь “тэнгэр ямар (уудам г.м)” гэдгийг илэрхийлнэ. Ойгоос гараад, доошоо харан чулуутай замаар алхсаны дараа, уулын оройд толгой дээр цэлийх тэнгэрийн уудмыг мэдрэх болов уу. “は/ва” болон “が/га” — Хялбар юм шиг хэрнээ хэцүү үг юм.

とも

2024年7月 夏季号

2024年7月1日発行

発行

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

<https://www.jitco.or.jp/>

電話

JITCO ホームページ